

Цорж лам Агваандоржийн монголоор зохиосон  
сан тахилгын судрын нэгэн хувилбар эхийн тухай

О.Дэмчигмаа\*

Агваандорж хэмээх энэ хүний намтар, үйл хэргийн талаар тодорхой өгүүлсэн сурвалж, судалгааны бүтээл одоо хэр үгүй бөгөөд 18-19 дүгээр зууны үеийн хүн, нийт 14 боть зохиолтой, олон түмэнд “Их хүрээний цорж, бичээч цорж Агваанцэрэн, Бичээч цорж, Да хүрээ цорж, Шавдун цорж, Шар цорж” зэрэг нэрээр алдаршсан гэхээс өөр лавтай мэдээ сэлт мэдэгдэхгүй байна. Тэрбээр “Учир шалтгааны ухаан”, “Винай”, “Нууц таршийн тайлбарууд”, “Дуун ухаан”- тайлбар, “Зохист аялгууны тайлбар, “Бодь мөрийн зэрэг”-ийн тайлбар, “Бодисадачаряаватар-гийн тайлбар, Өндөр гэгээний “Маанийг бүтээх гүн арга”-ын тайлбар, “Жидорын хамба Агваанхайдав /1779-1838/-ын “Залбирал хэлийн эрх баялаг”-ийн тайлбар - “Хэлийн эрх баялаг нэрт залбирлын тайлбар Лам багийн мөн чанарыг тодруулагч толь” зэрэг Энэтхэг, Төвд, Монголын эрдэмтдийн бүтээлүүдэд тайлбар хийсэн төдийгүй өөрийн бие даасан бүтээлүүд туурвисан нь нийт 550 гаруй зохиолоос бүрдсэн арван зургаан боть бүтээл болсон байдаг. Бас энэхүү бүтээлийн нь цоморлигт ороогүй, одоогоор бидэнд олдохгүй байгаа бүтээл нэлээд байна<sup>1</sup> хэмээн судлаач Р. Бямбаа гуай тэмдэглэжээ.

Зохиол бүтээлүүд нь ч судалгааны хүрээнд бүрэн ороогүй, Энэтхэгийн яруу найрагч Дандины “Зохист аялгууны толь”-ийн тайлбарын талаар акад. Ц.Дамдинсүрэн, Ш. Бира, О. Сүхбаатар, Х. Гаадан, “Учир шалтгааны ухаан”-ы бүтээлийн акад. Ц. Дамдинсүрэн, Ш. Бира, О. Сүхбаатар, Х. Гаадан, “Учир шалтгааны ухаан”-ы бүтээлийн талаар Р. Бямбаа нар судалгааныхаа бүтээлд дурдсан<sup>2</sup> төдий буй.

Бичээч цорж Агваандорж лам төвд хэлээр олон зохиол бүтээл туурвисны сацуу эх хэлээрээ ч бичиж байжээ. Үүний нэг нь нийт Монголын газар усны эздийг тахих зорилгоор зохиосон

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, Соёлын Сургууль

<sup>1</sup> Р. Бямбаа, *Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*, Уб., 2004, II боть. 627-р тал.

<sup>2</sup> Дээрх ном.

сан тахилгын судар аж. Уг зохиолыг Наймдугаар богдын үед монгол орон даяар тараасан<sup>3</sup> бөгөөд ард нийтэд хамгийн их түгж алдаршсан байна. Мөн монгол үсэг мэдэхгүй хүмүүст зориулж төвд хэлээр орчуулсан байдаг.<sup>4</sup> Энэхүү судар монгол бичгээр хуулагдан, хураангуй дэлгэрэнгүй хоёр хувилбараар ихэд дэлгэрчээ. Их хүрээнд модон бараар хэвлэгдсэн нь өдгөө мэр сэр тохиолдоно.<sup>5</sup> Эрдэмтэн О. Сүхбаатар гуай Цорж лам Агваандоржийн зохиосон “*Тэнгэр, дэлхий, газар орны сангийн судрын тухай*” нэрээр дэлгэрэнгүй хувилбарыг шинэ үсэгт хөрвүүлэн буулгаж, хураангуй эхийн хамт хэвлүүлжээ. Эхийг 16 мөрөөр, үзгээр тогтуун хичээнгүй бичсэн байна. Судлаач П. Сүхбат хураангуй хувилбарыг Богд Жавзандамба гэгээнтний айлдсан “*Дэлхийн эздийн сан тахилгын судар оршивой*” нэрээр, дэлгэрэнгүй хувилбарыг Цорж лам Агваандоржийн зохиосон “*Тэнгэр, дэлхий, газар орны сангийн судар оршив*” нэрээр тус тус шинэ үсгээр хэвлүүлжээ.<sup>6</sup>

### Эх хувилбаруудын тухайд:

#### 1. Гандан хийдийн номын санд №. 00121 дугаартай:

“*Цорж лам Агваандорж бээр зохиосон тэнгэр дэлхий газар орны сан тахилга оршивой*” нэртэй. Цаасны хэмжээ: 50.5 х 9.5 см, бичгийн хэмжээ: 45 х 6.8 см, мөрийн тоо: 20, хар бэхээр бичсэн, зохиогчийн сүмбүмийн “Б” ботийн 35 дугаарт нэг эх,<sup>7</sup>

#### 2. Акад. Ц. Дамдинсүрэн гуайн гэр музейд Ш1-87. (МН-292) дугаартай:

“*Цорж лам Агваандорж бээр зохиосон тэнгэр дэлхий газар орны сан тахилга оршивой*” нэртэй. Цаасны хэмжээ: 22.4 х 8.7 см, бичгийн хэмжээ: 20 х 6.7 см, мөрийн тоо: 19, хуудасны тоо: 11, хар бэхээр орос цаасан дээр бийрээр бичсэн нэг эх<sup>8</sup> тус тус хадгалагдаж байна.

3. Энд нийтлүүлж буй судрыг МУ-ын начин А. Сугна гуай хувьдаа хадгалж байсныгаа бидэнд өгсөн билээ.

Судрын бүтэн нэр нь: “*Цорж лам Агваандорж бээр зохиосон тэнгэр дэлхий, газар орны сан тахилга оршив*”. Цаасны хэмжээ: 22.3 х 9 см, бичгийн хэмжээ: 18 х 7.5 см, мөрийн тоо: 14, хуудасны тоо: 16. Орос цаасан дээр хар бэхээр бичсэн, бийрийн бичмэл судар.

Уг судрын элэгдэж хуучирсныг харахад нэлээд уншиж хэрэглэж байсан бололтой. Эхүүдээс харахад сан тахилгын энэхүү судар хуулбарлагдан өргөн тархсан, төвд хэлээр зохиогдсон бусад сангийн судруудаас ялгаатай, тухайлсан нэг уул усанд бус Халх нийтийн шүтээн уул усанд зориулагдсан болох нь тодорхой байна. Эх судрыг галиглан сийрүүлж, шинэ үсэгт хөрвүүлэн буулгаснаа зарим үгсийн тайлбарын хамт толилуулму.

<sup>3</sup> Дээрх ном.

<sup>4</sup> Дээрх ном.

<sup>5</sup> О. Сүхбаатар. *Монголын тахилгат уул усны сангийн судар оршивой*, Уб., 2000, 46 дугаар тал.

<sup>6</sup> П. Сүхбат, *Богд Очирваань Отгонтэнгэр хайрханы түүх шаштир, тайлга тахилга, зан үйлийн товчоон оршивой*, Уб., 2004, 1 дүгээр дэвтэр, 80-84, 90-99 дүгээр тал.

<sup>7</sup> Р. Бямбаа, *Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*, Уб., 2004, 2 дугаар боть, 752 дугаар тал.

<sup>8</sup> Г. Билгүүдэй, Ц. Дамдинсүрэнгийн гэр музейн монгол номын бүртгэл, 1 боть, Уб., 1998, 278 дугаар тал. 1045.

**Čorji blam-a Ngavangdorji-ber jokiyaysan  
tengri delekei ʔajar orun-u sang takily-a orusiba**

16. 01. Boyda blam-a jibjungdamba [=jibjungdamba]

02. burqan-a mörgümüi, takimui,

03. itegemüi. öberün [=öber-ün]

04. törügsen nutuy ba

05. ayuluysan delekei

06. ʔajar usun-u ejed-i

07. takisuyai kemebesü

08. idegen-ü jüyil alin

09. bui-yin degeji-i [=degeji-yi]

10. beledbesü erkim ügei

11. čü bolba agi arča

12. terigüten-i sitayaju eyin

13. ögülegdeküi. Blam-a burqan

14. nom ba bursang quvaray

2a. 01. - uud-ta [=uud-tu] bodi qutuy-i

02. olun oltal-a itegemüi.

03. bi. Minu öglig [=öglige] öggügsen

04. terigüten buyan-u küčün

05. - iyer amitan-a tuslaqu-yin

06. tula burqan bolqu minu

07. boltuyai.

08. *kemen ʔurban ta ögüle.*

09. qamuy amitan amuyulang

10. ba amuyulang-un siltayan

11. luy-a tegülder boltuyai.

12. qamuy amitan jobulang [=jobalang] ba

13. jobulang-un siltayan-ača

14. anggijiraqu boltuyai.

2b. 01. qamuy amitan jobulang ügei

02. amuyulang-ača büü anggijirtuyai.

03. qamuy amitan oyir-a qola

04. tačiyaqu urilaqu qoyar

05. -ača anggijraysan tegsi

06. sedkil-iyer aqu boltuyai.

07. *kemen ʔurban-ta ögüle.*

08. bi öber-iyen nigen gšan-a

09. včirbani burqan bolbai.

10. om bajar amirda gündali

10. han-a han-a hum pad

11. takil ariyulal-dur aysan

12. bujar tüyidker todqarlayčün

3a. 01. čöm usudbai. Om

02. suvavaba süddü ham

03. takil tabay [=tabiy] ariyulal čöm

04. qoyusun kü bolbai. Qoyusun

05. činarun [=činar-un] ayar-ača bhrum

06. üsüg ileren ʔarču qayiluyad

07. erdeni-yin yeke saba boluysan-u  
 08. dotur-a om a hum  
 09. üsüg ileren γarču  
 10. qayiluyad qamuy bujar  
 11. tüyidker-i arilyaju  
 12. ariyulal ba jayun amtatu  
 13. elbeg barasi ügei joyuy  
 14. takil belge bilig-un mön
- 3b. 01. činartu rasiyan bolbai.  
 02. om a hum *kemen γurban-ta*  
 03. *ögüle*. Om sarva bid  
 04. бүр-е бүр-е сүр сүр  
 05. avarday-a avarday-a ho  
 06. bajar paran-a ham  
 07. *kemen γurban-ta ögüle*.  
 08. eyin minu sanaysan-u küčün  
 09. ba tegünčilen aǰiraysan  
 10. burqan-u adistid-un  
 11. küčün kiged nom-un ayar-un  
 12. küčün-iyer minu alin  
 13. sanaysad čöm tere  
 14. yosuyar toraqu [=torqu] türbekü
- 4a. 01. ügei bolqu boltuyai.  
 02. ay-a delekei-yin arban  
 03. buyan-u belge бүридүгсен [=bүridүгсен]  
 04. öljei kisig [=kesig] togtuysan [=togtaysan]  
 05. čoy edlel-iyer delger  
 06. ene yeke mongγul qalq-a-yin  
 07. nutuy daki tuqai du  
 08. ayula γajar usun-u  
 09. ner-e-i oruyulsuyai.  
 10. kemebesü ene jabsar  
 11. oruyulbasu bolumui.  
 12. man-u törügsen nutuy ba  
 13. ayuluysan delekei-yin eki  
 14. aday-un ayula tala modu
- 4b. 01. čilayu qada asq-a γoul  
 02. usu jülge namuy qujir  
 03. deresü jam kötül terigüten-e  
 04. aγči čaylasi ügei buyan-u  
 05. čoy jibqulang badaraysan  
 06. dalai metü yang sang-iyar  
 07. čenggelegsen yeke ridi  
 08. qubilγan auy-a küčütü  
 09. ene oron-u kümün mal-i  
 10. ibegen asarayči tengri [=tngri]  
 11. luus nayiman ayimay delekei  
 12. - yin eǰed qatud agi nar

13. түсiмeд барaдaгчид [=барaдaгчид]<sup>9</sup> чөм-i  
 14. урин жaлaмui. Bayasqulang-un
- 5a. 01. gegen bayidal-iyar engde [=ende] ајiran  
 02. жалармui. Emün-e erdeni-yin  
 03. ordu qarsi örgüге tal-a  
 04. metü ағујim-un dotura [=dotur-a]  
 05. erdeni-yin sangdali [=sandali] torь-a  
 06. mangnuу ariyatan-u arisun [=arasun]  
 07. olbay [=olbuу] debesker-dür [=debisker-tür]  
 08. amуyulang sayiqan-iyar  
 09. tablan sayumu. Bodatai  
 10. beleddügsen [= beledügsen] ba sanayan-ača  
 11. ғарaғaу tarini mutur-a  
 12. samidi<sup>10</sup>-bar rasiyan-u  
 13. dalai bolьan adislaysan  
 14. süü čai ariki ayiray
- 5b. 01. taray uuray [=ууруау] ағарča örüm  
 02. amtatan јimis miq-a tatasi  
 03. үlir tosu terigüten  
 04. eldebe [=eldeb] idegen-ü degeјi  
 05. јoyуу qurim-i ergümüi.  
 06. torь-a mangnuу qubčid  
 07. eldeb olbay debisker  
 08. ariyatan görüged-ün arisu [=arasu]  
 09. qaday torь-a mangnuу böс  
 10. gkib terigüten edlel-i  
 11. ergümüi. Quуay duууly-a  
 12. buu јida selem-e terigüten  
 13. meses ba erdeni torьan-u  
 14. čimeg јemseg bayising
- 6a. 01. örgüге eldeb em ür-e  
 02. erdeni-yin sang-i ergümüi.  
 03. külge [=külüg] mori temege qoni  
 04. üker sarлуу qayinuy  
 05. ariyatan görügesün eldeb  
 06. sibayud-un sürtüg-i ergümüi.  
 07. akar [=ағар] zandan agi arča  
 08. terigülen eldebe [=eldeb] ünüd-i  
 09. bisqaryulun [=bisqarayulun] sitayaysan  
 10. utayan-iyar delekei-yin eјed  
 11. yuуan [=ууан] ariyulmui. Qamuy  
 12. bujar tüyidker čöm  
 13. ariyudqu boltуai.  
 14. čöb čay-un bide mungqay
- 6b. 01. engdegü balmad-un erkeber [=erke-ber]  
 02. kingsigütü kirbusu sitayaysan  
 03. bujar burtay talbiysan

<sup>9</sup> Бараадагчид гэсэн үг.<sup>10</sup> Самади

04. qoruqai ariyatan  
 05. görüged-i qoorlaysan  
 06. ʔaʔar usu köndügsen  
 07. modu oytulurysan čilayü  
 08. qobqulurysan ulai  
 09. ʔarʔaysan kerüldün  
 10. čuugildurysan ongyun  
 11. ʔaʔar-du [= ʔaʔar-tu] bayudal jasaysan  
 12. orun-u tengri [=tngri] delekei-yin  
 13. eʔed-i ese qayiqaraysan  
 14. ači tusa-i medeʔü čay čay
- 7a. 01. -du [= -tu] ese tayiysan čoy  
 02. jibqulang badarʔulqui [= badarʔulqui]  
 03. ba ʔaʔar-un sim-e arbidqu  
 04. -yin arʔ-a-tur ese kičiyegsen  
 05. terigüten delekei-yin eʔed-ün  
 06. tayalal-dur qarsiysan bükün  
 07. -iyen dayudan namangčilamui.  
 08. šašin-i ergümjilekü ügei  
 09. törü-i keresegüü ügei blam-a  
 10. baysi nar-i takiqu ügei  
 11. toyid quvaray-i küngdelekü [=kündülekü]  
 12. ügei ečege [= ečiǵe] eke-i qayiqaraqu  
 13. ügei aqamad-i küngdelekü [=kündülekü]  
 14. ügei yabudasun-i jočilaqu
- 7b. 01. ügei ʔuiliyčan-a [=ʔuyulyačın-a] ögkü  
 02. ügei terigüten delekei-yir  
 03. eʔed-ün tayalal-dur  
 04. qarsiysan bükün-iyen  
 05. dayudan namangčilamui. Sayin  
 06. jirum-i gegekü mayu oblal-i  
 07. örbedkekü amitan-i soylan [=šoylan]  
 08. qoorlaqu darulaqu  
 09. basuqu qulayayilaqu aldayulqu  
 10. qayurqu basirdaqu qariyaqu  
 11. qayačaldayulqu ösikü  
 12. qobduylaqu ünen ildam-i  
 13. sakiqu ügei jöriǵüü  
 14. ʔajiyuu-i kičiyekü terigüten
- 8a. 01. delekei-yin eʔed-ün tayalal  
 02. -dur qarsiysan bükün-iyen  
 03. dayudan namangčilamui. Tere  
 04. metü-yin olan mayu yabudal-i  
 05. öǵüljü güyičesi ügei tula  
 06. tobčilabasu orun delekei-yin  
 07. eʔed-ün tayalal-dur qarsiysan  
 08. sür buyan-i tan-i ʔutayaysan  
 09. mön öberün [=öber-ün] ʔayay-a buyan-i  
 10. buliduysan orun dakin-a sayin-i  
 11. qomsudqan mayu elbeksikü

12. mayu yabudal-iyar yabuysan  
 13. -iyan čöm dayudan namangčilamui.  
 14. ayučılan örüsüyejü külicemü
- 8b. 01. ibegegčid minu\_e. Man-u  
 02. eyimü olan mayu yabudal  
 03. ba jarim toyid-un čalayai  
 04. terigülügčid-ün jorimay  
 05. arad-un engdegü-yin čalidas  
 06. - iyar delekei yaĵar-un kisig [=kesig]  
 07. bayuysan [=bayuraysan] čay-un bayiri  
 08. urbaysan orun delekei-yin  
 09. eĵed-ün auy-a küčün  
 10. sür sülde-dür gem boluysan  
 11. čöm ene ariyulal-iyar  
 12. ariyudan selberekü boltuyai.  
 13. yertenčü [=yirtinčü] dayayar gürtin-i  
 14. eĵen Eserün qormusta nar
- 9a. 01. ču burqan Šayjimuni-yin  
 02. gegen-e sögüdügsen-ü  
 03. tula mön delekei-yin eĵed tan-u  
 04. abural-un orun mön tolidču [=tolidaĵu]  
 05. burqan-u šasin küngdülen [=kündülen] sakiĵu  
 06. boyda blam-a narun[=nar-un] ölmei  
 07. batudqaju olan bursang  
 08. quvaray-i tetkün kögĵigülümü.  
 09. Manĵusiri boyda eĵed bolun  
 10. qad noyad-un ölĵei-i batudqan  
 11. sür jibqulang čoy-i inu  
 12. degdegen tügemel törü-i  
 13. töbsidken engkeĵigülümü.  
 14. öglig-yin [=öglige-yin] eĵed ba man-u
- 9b. 01. kümün mal edlel-dür  
 02. qoorlayči dayisun qulayai  
 03. degerim [=degerem] qoruqai šabiĵi [=sibaĵi]  
 04. činu-a ariyatan-u könügel-i  
 05. usudqamu. ĵai ursiy  
 06. kertüĵil [=keregül] čuugiyān kele aman  
 07. ebedčün taqul bügüde-eče  
 08. ĵayilayulumu. širigün [=širügün] qur-a  
 09. času šiyury-a qabsury-a  
 10. ĵang ĵud-un ayul ügei  
 11. öng öyüg tabtai tayibung  
 12. - iyar amurĵiyulumu. Eteged  
 13. - ün šoyalal [=šoylal] busud-un mayu  
 14. sanay-a ĵal tüyimer usu
- 10a. 01. üyür [=üyer] čakilyan ayungy-a  
 02. luu unĵiĵu yaĵar  
 03. dolĵisqu terigüten luy-a  
 04. büü učiryulumu [=učarayulumu]. On  
 05. čay tegsi gem ügei olĵa

06. asiy uçirqu [=uçaraq] tariy-a ebesü  
 07. boruy simetei esen engke  
 08. - ber jirayulumu [=jirayulumu]. Nasu  
 09. urtu çoy jibqulang kei  
 10. mori delgeren köbegün şabi  
 11. nar-iyar olan, ile dalda  
 12. yekes asaran, sayin nökiid  
 13. sadun luy-a uçiran [=uçaran]aliba  
 14. sanaysad-i daray-a-bar
- 10b. 01. güyiçeldegülümü. Orun  
 02. nutuy-dur öljei kisig-i [kesig-i]  
 03. toytayaju olan arad  
 04. siduryu sedkil-iyer  
 05. jokildun, teligün amuray  
 06. - iyar nayiraldun bayalay [=bayaliy]  
 07. elbeg-iyer çenggildegülinü [=çenggeldügülümü].  
 08. tal-a degüürin [=dügürens] adayu  
 09. temege, qota degüürin [=dügürens]qoni  
 10. ükerün [=üker-ün] kisig-i [=kesig-i] örüsiyemü.  
 11. baraydaqı ügei aman-u  
 12. kisig, bayuraqu ügei  
 13. jayay-a buyan-u kisig-i  
 14. örüsiyemü. Tasuraqu ügei
- 11a. 01. ür-e üngdüsü [=ündüsü] sanayan-u  
 02. adali büli jaruçan-u kisig-i  
 03. örüsiyemü. Sayurin-dur  
 04. kümün mal çöm amur ayan  
 05. yabudal-dur tuuly-a [=tayuly-a] mengdü [=mendü]  
 06. yabudal silayun [=silayun] joriysan kereg  
 07. çöm-i güyiçeldegülümü. Bide  
 08. öglig [=öglige]-yin ejed kümün mal  
 09. edlel çöm-i delekei-yin ejed  
 10. qayırqad-dayan [=qairqag-tayan] dayadqamui.  
 11. urilaqu dayisun-i sönügen  
 12. qoorlayçi todqad-i darulamu.  
 13. çidaqu ügei-i [=ügei-yi] elben, medekü  
 14. ügei-yi sanayulumu. Tögereküi [=tögeriküi]
- 11b. 01. - dür yajarçilan yayçayardaqui  
 02. - dur nökiirlemü. Darulaydaqı  
 03. - dur körkidün, deyildeküi  
 04. - dür qamayalaşamu [=qamayalaçamu]. Ünen  
 05. siduryu-i kiçiyekü, eteged  
 06. buruy-u-iyar [=buruy-u-bar] jorimaylaqu-i [=jorimaylaqu-yi]  
 07. ilyamu. Emün-e-eçe urytaju  
 08. qoyin-a-aça dayan sakımu.  
 09. yuljayıysan-i jalaju  
 10. tasuraysan-i jalayamu.  
 11. Unuysan-i bosqan, martaysan-i  
 12. serigülmü. Aldaysan-i olyun  
 13. ayuqui-dur sakımu. Edür



14. qariuyuldun, söni manan
- 12a. 01. ibegemü. Erkelen könggiçilen [=könggeçilen]  
 02. tumaraqı minı busu  
 03. öberün [=öber-ün] çidal buyan mökü<sup>11</sup>[=meküs]  
 04. edüge ene çay-un arad  
 05. jörigüü, qamuy бүкүн  
 06. qomsu, γayçakü egerel-ün  
 07. γajar ibegeltü qayırqad  
 08. - dayan itegen γuyuju  
 09. jalbiral bölüge. Tengri-yin  
 10. nidün-iyer qarçu [=qaraju], tengri-yin  
 11. çikin-iyer sonusçu gegen  
 12. toli-bar tolidçu [=tolidaju] türbekü  
 13. ügei ridi qubilyan-iyar  
 14. - iyan ilete tedkemü. Man-u
- 12b. 01. üyiledbüri olan yabudal  
 02. aburi бүдүгүн dalda-i [=dalda-yi]  
 03. medekü ügei-yin erke-ber  
 04. γajar usu modu çilayu  
 05. köngdekü [= köndekü] ongyun γajar-du [=γajar-tu]  
 06. qonurylaqu üdlekü<sup>12</sup> [=üdelekü] bayuça  
 07. jasaqu terigüten üyile  
 08. yayun-i üyiledbeçü  
 09. ungdıyüçaqu damarlaqu  
 10. atayaçaqu toquurqaqu  
 11. öselekü [=öslekü] terigüten ügei  
 12. qarin yabudal keregtü [=kereg-tü] mani  
 13. demjimü. Ertençe [=erte-eçe] ibegen  
 14. örüsiyegsen açi-i [=açi-yi] açılaqu
- 13a. 01. ba jiči niγur bolyan  
 02. ergükü joyuy bilig [=beleg] edeger  
 03. - i küliyen abçu qurimlan  
 04. çenggejü γuyun jalbiraysad  
 05. - i minı mön yosuyar  
 06. bolyan jokiyamu. Qamuy-i  
 07. ayiladduyçi burqan  
 08. Şayjimuni-yin jarliy-dur [=jarliy-tur]  
 09. kilingçe yayun-i çu büü  
 10. üyiled. Buyan-i qotala  
 11. tegülder-iyer edlegtün.  
 12. öberün sedkil-iyen  
 13. amuyuyaytun. Ene inu  
 14. burqan-u suryal üjegülügdekün  
 15. hölüge. Qorin<sup>13</sup> üyiledügsen
- 13b. 01. yayun бүгүде-i [=bügüde-yi] odun  
 02. bürgüljelel, jula ba jali

<sup>11</sup> Нэгдүгээр үеийн "ө"-гийн шилбийг тавиагүй байна.

<sup>12</sup> Эхний үеийг шилбэгүй, "д"-г ардаа эгшиггүй хэвтээ "д"-гээр бичжээ.

<sup>13</sup> О. Сүхбаатар гуайн хэвлүүлсэн эхэд "хуран" гэж буй.

03. següder usun çöbergü [=çöbürigüü]  
 04. jëgüde čakilyan egüle adali  
 05. üjegtün. Meses-eçe ülü  
 06. ayuqu ken ügei. ükükü  
 07. ami-i [=ami-yi] bügüdeger çegerlemüi.  
 08. öberün bey-e-eçe üliġer  
 09. abçu busud-tan [busud-tayan] qoorlal  
 10. büü üyileddüġtün kemegsen  
 11. nomun [=nom-un] öġlig [=öġlige] bolyan ergüsüġei  
 12. sangsar [=sansar] nirvan-u sayin öljëi  
 13. çoy jali küçün uçiral [=uçaral]  
 14. nasu buyan sayin aldar idege
- 14a. 01. qubčid ed malun [=mal-un] qamuy  
 02. kesig iritüġei. Qurui  
 03. qurui. Kejij-e-tü [=kejijede] yayun  
 04. - iyar çu möküsdëkü ügei  
 05. yeke kesig-i örüsiyemü.  
 06. Oytaryui-yin sang-du [=sang tu] bayan  
 07. delekei-yin ejed minu\_e  
 08. ay-a yurban erdeni-yin  
 09. adistid ba bide nutuy  
 10. - un arad dakin-u buyan öljëi  
 11. ünë nomun [=nom-un] çinar sayin beleg  
 12. - üüd-ün küçün-iyer delekei-yin  
 13. ejed-dür [=ejed-tür] qarsi ügei  
 14. çayan jüg-i tedkekü sür
- 14b. 01. jibqulang anu badaraq  
 02. boltuyai. Orun-u ejed-ün  
 03. ali tayalaysan bügüde  
 04. minu ene takil-aça yarçu  
 05. tayalal-i tan-i güyiçeldegülkü  
 06. boltuyai. Qayırqad nar ba  
 07. door-a qoryuduyusan bide  
 08. nar çöm eke köbegün  
 09. adali amuray sayıqan-iyar  
 10. orusiju, tegünü [=tegün-ü] küçün-iyer  
 11. orun dakin dayayar amur  
 12. jiryaqu mani boltuyai.  
 13. Edüġe delekei-yin ejed-i  
 14. takiqi-tayan aldal gem  
 15. boluysan bui abasu man-u
- 15a. 01. mungqay tenëg-ün yabudal-i  
 02. ayuçılan külicemü. Man-u  
 03. ergügsen-i abçu öçigsen-i  
 04. tungqay [=tungyan] tus tusa [=tus] ordun  
 05. - dayan tekereġed jiči jalaqui  
 06. büri jalaran irigseġer [=iregseġer]  
 07. nasuda qarayaljan örüsiyemü.  
 08. Orun-u ejed minu\_e. eke  
 09. açitu blam-a yidam burqad

10. - un öljei qutuy orusitu-  
 11. - γai. Abural γurban  
 12. erdeni-yin öljei qutuy  
 13. orusituyai. Eke bayatur  
 14. daginis-un öljei qutuy
- 15b. 01. orusituyai. Kүүүтү  
 02. nom-un sakiγulsun narun [=nar-un]  
 03. öljei qutuy orusituyai.  
 04. Tengris orun-u ejed-ün  
 05. öljei qutuy orusituyai.  
 06. ali sanaysan kereg бүтүкү  
 07. - yin öljei qutuy orusi-  
 08. - tuyai. Edür söni-yin  
 09. çay бүгүде-dü amuyulang  
 10. - iyar çenggekü-yin öljei  
 11. qutuy orusituyai.  
 12. kemen ögülegedkü. Yerü degedüs  
 13. - ün jökiγarγsan delekei-yin ejed-ün  
 14. tayilyan-u sudur neng olan
- 16a. 01. adis yeketei, ertençe [=erte-eçe] öljei  
 02. bolurγarγar iresen [=iregsen] gebeçü çöm  
 03. töbed-ün kele höged γajarun [=γajar-un]  
 04. ejed jarim-uud anu ülü uqaqu  
 05. bolγusi ügei mön eng-ün  
 06. mongγulçud medekü ügei mongγulçil-  
 07. - basu ur töbed-ün ögülekü bayidal-i  
 08. darγaldarγulju uçir-iyar mongγul-un  
 09. kelen-dü yahkitel-e neyileçekü ügei  
 10. böged ur sanarγ-a ünner-e sayitur  
 11. bürin-iyer medeküi-e berkeleg singki  
 12. sanabasu mongγul-un delekei-yin  
 13. ejed-dü [=ejed-tü] mongγul-un idege  
 14. beledçü mongγul-un üge-ber
- 16b. 01. joriγulju uçir joriγ-iyar  
 02. darγudaγu ögülebesü qarın  
 03. mongγul-un orun-darγan öljei  
 04. bilig dei, [=belgetei] geküi-yin γadan-a  
 05. eng-ün mongγulçud  
 06. uçir-i medeγu süsüleldükü  
 07. sanarγ-a olumu kemekü sanarγ-a  
 08. sitüjü boyda narun [=nar-un] jökiγarγsan  
 09. sudur-uud-un bayiri sanarγ-a  
 10. abçu eyin ebsegülbe.  
 Mang galam-a. Om ma ni bad mei hum.

16. Богд лам Жавзандамба бурханаа мөргөмүй, тахимуй, итгэмүй. Өөрийн торсөн нутаг ба агуулсан дэлхий, газар усны эздийг тахисугай хэмээвээс: идээний зүйл алин буйн

дээжийг бэлдвээс эрхэм үгүй ч болов агь арц тэргүүтнийг шатааж ийн өгүүлэгдэхүй<sup>14</sup>.

“Лам, бурхан, ном ба бурсан хувраг

- 2а. -уудад бодь хутгийг олон олтол итгэмүй би. Миний өглөг өгсөн тэргүүтэн буяны хүчээр амьтнаа туслахын тул бурхан болох минь болтугай” хэмээн гурвантаа өгүүл. Хамаг амьтан амгалан ба амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай. Хамаг амьтан зовлон ба зовлонгийн шалтгаанаас ангижрах болтугай.
- 2б. Хамаг амьтан зовлонгүй амгалангаас бүү ангижиртугай. Хамаг амьтан ойр хол, тачаах урилах хоёроос ангижирсан тэгш сэтгэлээр аху<sup>15</sup> болтугай” хэмээн гурвантаа өгүүл. Би өөрөө нэгэн агшинаа О ирваань бурхан болвой. “Ум базар амрида гүндалн ха на ха на хум пад”<sup>16</sup>. Тахил ариулалд агсан бузар түйтгэр тотгорлогчин
- 3а. цөм уствай. “Ум сувава сүддү хам”<sup>17</sup> тахил тавиг ариулал цөм хоосон хү болвой. Хоосон чанарын агаараас Вхрүм үсэг илрэн гарч хайлаад, эрдэнийн их сав болсны дотор “Ум аа хум”<sup>18</sup> үсэг илрэн гарч хайлаад, хамаг бузар түйтгэрийг арилгаж, ариулал ба зуун амтат элбэг баршгүй зоог тахил, бэлгэ билгийн мөн
- 3б. чанарт рашаан болбой. “Ум аа хум” хэмээн гурвантаа өгүүл. “Ум сарва вид бүр бүр, сүр сүр авардияа авардияа хо базар барана хам”<sup>19</sup> хэмээн гурвантаа өгүүл. Ийн миний санасны хүч ба түүнчлэн ажирсан бурханы адистидын хүч хийгээд номын агаарын хүчээр цөм тэр ёсоор торох дүрвэх<sup>20</sup>
- 4а. үгүй болох болтугай. Аяа дэлхийн арван буяны бэлгэ бүрдсэн өлзий хишиг тогтсон цог эдлэлээр дэлгэр энэ их Монгол Халхын нутаг дахь тухайт уул газар усны нэрийг оруулсугай хэмээвээс: энэ завсар оруулбаас болмуй. Манай төрсөн нутаг ба агуулсан дэлхийн эх адгийн уул тал, мод
- 4б. чулуу, хад асга, гол ус, зүлэг намаг, хужир дэрс, зам хөтөл тэргүүтнээ агч цаглашгүй буяны цог жавхлан бадарсан далай мэт, ган сангаар цэнгэлсэн<sup>21</sup> их рид хувилгаан лугаа хүчит энэ орны хүн малыг ивээн асрагч тэнгэр, лус найман аймаг<sup>22</sup>, дэлхийн эзэд, хатад, агь нар, түшмэд бараадагчид цөмийг урин залмуй. Баясгалангийн
- 5а. гэгээн байдлаар энд ажран залармуй. Өмнө эрдэнийн орд харш өргөө тал мэт уужмын дотор, эрдэнийн сандал, торго магнаг, араатны арьсан олбог дэвсгэрт амгалан сайхнаар

<sup>14</sup> “Өгүүлэгтүн” хэмээх үгийн эртний хэлбэр.

<sup>15</sup> Байх хэмээсэн утга.

<sup>16</sup> Амрида-гийн Мрида нь: үхэх хийгээд А нь үгүйсгэх үг. Нийлээд “үхэлгүй” гэсэн утга болох буюу рашаанд урвуулах тарни болой. Хум пад нь тодруулан үйлдэх болой. /Уул овооны сан тахилгын судрууд. Ерөнхий редактор Д. Мөнхсайхан. Уб. 2004. 350дугаар тал/. Газар дэлхийн эздэд балин тахил өргөхдөө уг тарнийг уншиж, өргөл идээгээ рашаан болгон хувиргаж адисладаг ажээ. Энэхүү сударт: өөрийгөө Очирваань бурхан болов хэмээн бясалгаад, энэ тарнийг унших тухай өгүүлжээ.

<sup>17</sup> Энэхүү тарниар тахил ариуллын зүйлсийг хоосон чанарт болгон адисладаг аж.

<sup>18</sup> Ум нь тарнийн эхийг татах бөгөөд Хум нь тааллын хөрөнгө бөгөөд адистидлан үйлдэх болой.

<sup>19</sup> Ум нь мөргөх хийгээд өлзий хутаг тэргүүтэн олон утгаар ордог. Сарва вид нь хамгийг ухаарах, бүр бүр нь дүүргэх буюу төгсгөн үйлдэгтүн буюу болтугай хоёр, сүр сүр нь түгэх буюу үзэсгэлэнтэй болтугай хоёр. Хо нь Аяа хэмээн дуудах, базар парана хам нь Очир огторгуйд цацар хэмээх болой. Энэхүү тарниар тахил ариуллын зүйлийг ариусган адистидладаг байна.

<sup>20</sup> Аливаа хэрэг явдал түдэхгүй, саадгүй гэсэн утгатай үг.

<sup>21</sup> “Цэнгэх”-ийн олуул үйлдэх хэлбэр.

<sup>22</sup> Лусын найман их хаан байдаг. 1. Хязгааргүй. Са. Ananta, Тө. འཇགས་པལ། 2. Талбну, Са. Taksaka, Тө. འཇགས་པོ། 3. Язгуур төгс. Са. Kulika, Тө. རྒྱལ་མཚན། 4. Дун сахигч. Са. Sankhapala, Тө. རྩལ་སྐྱོང་པ། 5. Хүчний шалтгаан. Са. Karkatika, Тө. རྩལ་སྐྱོང་པ། 6. Их лянхуа. Са. Mahapadma, Тө. རྩལ་སྐྱོང་པོ། 7. Эд дэлгэр. Са. Vasuki, Тө. རྩལ་སྐྱོང་པ། 8. Бадам. Са. Padma, Тө. རྩལ་སྐྱོང་པ།

тавлан сууму. Бодтой бэлдсэн ба санаанаас гаргаж, тарни, мутраа, самадигаар рашааны далай болгон адисласан сүү цай, архи айраг,

- 56.** тараг уураг, аарц өрөм, амтаг жимс, мах таташ, гурил тос тэргүүтэн элдэв идээний дээж зоог хуримыг өргөмүй. Торго магнаг хувчид, элдэв олбог дэвсгэр, араатан гөрөөдийн арьс, хадаг, торго магнаг, бөс хив тэргүүтэн эдлэлийг өргөмүй. Хуяг дуулга, буу жад, сэлэм тэргүүтэн мэсэс ба эрдэнэ торгоны чимэг зэмсэг, байшин
- 6а.** өргөө, элдэв эм үр, эрдэнийн санг өргөмүй. Хүлэг морь, тэмээ, хонь, үхэр, сарлаг, хайнаг, араатан гөрөөсөн, элдэв шувуудын сүргийг өргөмүй. Агар зандан, агь арц тэргүүлэн элдэв үнэдийг<sup>23</sup> бясхаруулан<sup>24</sup> шатаасан утаагаар дэлхийн эзэд юугаан ариулмуй. Хамаг бузар түйтгэр цөм ариулах болтугай. Цөв цагийн бид мунхаг,
- 6б.** эндүү балмадын эрхээр хиншгү хярвас шатаасан, бузар буртаг тавьсан, хорхой, араатан гөрөөдийг хорлосон, газар ус хөндсөн, мод огтолсон, чулуу ховхолсон, улай гаргасан, хэрэлдэн цуугилдсан, онгон газарт буудал зассан, орны тэнгэр дэлхийн эздийг эс хайхарсан, ач тусыг мэдэж цаг цаг
- 7а.** -т эс тайсан, цог жавхлан бадруулах ба газрын шим арвитахын аргад эс хичээсэн тэргүүтэн, дэлхийн эздийн таалалд харшсан бүхнээ дуудан наманчилмуй. Шашныг өргөмжлөхгүй, төрийг хэрсүүгүй<sup>25</sup>, лам багш нарыг тахихгүй, тойд хуврагийг хүндлэхгүй, эцэг эхийг хайхрахгүй, ахмадыг хүндлэхгүй, явдсаныг<sup>26</sup> зочлох
- 7б.** - гүй, гуйлгачнаа өгөхгүй тэргүүтэн, дэлхийн эздийн таалалд харшсан бүхнээ дуудан наманчилмуй. Сайн журмыг гээх, муу овлолыг үрвэтгэх<sup>27</sup>, амьтныг шоглон хорлох, дарлах, басах, хулгайлах, алдуулах, хуурах, баширдах, хараах, хагацалдуулах, өших, ховдоглох, үнэн ялдамьг сахихгүй, зөрүү гажууг хичээх тэргүүтэн,
- 8а.** дэлхийн эздийн таалалд харшсан бүхнээ дуудан наманчилмуй. Тэр мэтийн олон муу явдлыг өгүүлж гүйцэшгүй тул товчилбоос: орон дэлхийн эздийн таалалд харшсан, сүр буяныг тань гутаасан, мөн өөрийн заяа буяныг бульдсан<sup>28</sup>, орон дахинаа сайныг хомстгон, муу элбэгших муу явдлаар явснаа цөм дуудан наманчилмуй. Уучлан өршөөж хүлцмү.
- 8б.** Ивээгчид минь ээ. Манай ийм олон муу явдал ба зарим тойдын цалгай тэргүүлэгчдийн зоримог ардын эндүүгийн цальдсаар дэлхий газрын хишиг буурсан, цагийн байр урвасан, орон дэлхийн эздийн аугаа хүч сүр сүлдэнд гэм болсон, цөм энэ ариуллаар ариудан сэлбэрэх болтугай. Ертөнц даяар гүрний эзэн Эсрэн хурмаст нар
- 9а.** ч бурхан Шагжамунийн гэгээнээ сүслэн сөгдсөний тул мөн дэлхийн эзэд таны авралын орон мөн тольдож, бурханы шашин хүндлэн сахиж, богд лам нарын өлмий бататгаж, олон бурсан хуврагийг тэтгэн хөгжүүлмү. Манзушир богд эзэд болон хаад ноёдын өлзийг бататган, сүр жавхлан цогийг нь дэгдээн, түгээмэл төрийг түвшитгэн

<sup>23</sup> “Үнэртэн”-ий олон тоо.

<sup>24</sup> “bil” хэмээх язгуураас авианы хувирлаар үүсэн үг. Бялах дүүрэх гэсэн утгатай. /Сэцэнцогт. *Монгол үгсийн язгуурын толь*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1988. 720-дугаар талд үз/. Энд баагиулах, ихээр, бөөнөөр шатаах, уугиулах гэсэн утгаар оржээ.

<sup>25</sup> О. Сүхбаатар гуайн хэвлүүлсэн эхэд “хэрэгсэхгүй” хэмээн бичсэн буй.

<sup>26</sup> Замын хүн, явуулын хүн гэсэн утгаар ийн өгүүлсэн байна.

<sup>27</sup> Үрвэтэх, үрэвсэх - 1. галын багаас их болж дүрэлзэх, бадрах, 2. олшрох, үржих, 3. нэг юм нөгөөд нэвчих, тэлэх. 4. дам цуу үгийг цуурхан дэмий хэлэлцэх. /*Монгол хэлний толь*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999. 696-697 дугаар талд үз/. Муу ов залиг дэврээх, ихэсгэх гэсэн утгатай байна.

<sup>28</sup> Бульдах - юмыг элбэгжүү хэрэглэх, бялгадах. /*Монгол хэлний толь*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999. 1031 дүгээр талд үз/.

- энхжүүлмү. Өглөгийн эзэд ба манай
96. Хүн, мал, эдлэлд хорлогч дайсан, хулгай дээрэм, хорхой шавьж, чоно араатны хөнөөлийг устгаму. Гай уршиг, хэрүүл цуугиан, хэл ам, өвчин тахал бүгдээс зайлуулму. Ширүүн хур, цас шуурга, хавсарга, ган зудын аюулгүй өн өөг, тавтай тайвнаар амаржуулму. Этгээдийн шоглол, бусдын муу санаа, гал түймэр, ус
- 10а. үер, цахилгаан аянга, луу унжих, газар долгисох тэргүүтэн лугаа бүү учруулму. Он цаг тэгш, гэмгүй, олз ашиг учрах, тариа өвс борог шимтэй эсэн энхээр жаргуулму. Нас урт, цог жавхлан, хийморь дэлгэрэн хөвгүүн шавь нараар олон, ил далд ихэс асран, сайн нөхөд садан лугаа учран, аливаа санагсдыг дараагаар
- 10б. гүйцэлдүүлмү. Орон нутагт өлзий хишгийг тогтоож, олон ард шударга сэтгэлээр зохилдон, тэлүүн амрагаар найралдан, баялаг элбэгээр цэнгэлдүүлмү. Тал дүүрэн адуу тэмээ, хот дүүрэн хонь үхрийн хишгийг өршөөмү. Барагдахгүй амны хишиг, буурахгүй заяа буяны хишгийг өршөөмү. Тасрахгүй
- 11а. үр үндэс, санааны адил бүл зарцны хишгийг өршөөмү. Сууринд хүн мал цөм амар, аян явдалд туулга мэнд<sup>29</sup>, явдал шулуун, зорьсон хэрэг цөмийг гүйцэлдүүлмү. Бид өглөгийн эзэд, хүн мал, эдлэл цөмийг дэлхийн эзэд хайрхандаа даатгамуй. Урилах<sup>30</sup> дайсныг сөнөөн, хорлогч тотгодыг дарламу. Чадахгүйг элбэн, мэдэхгүйг сануулму. Төөрөх
- 11б. -д газарчлан, ганцаардахад нөхөрлөмү. Дарлагдахад хөөрхийдөн, дийлдэхэд хамгаалалцму. Үнэн шударгыг хичээх, этгээд буруугаар зоримоглохыг ялгаму. Өмнөөс угтаж хойноос даган сахимуй. Гулзайсныг залж, тасарсныг залгаму. Унасныг босгон, мартсаныг сэрүүлмү. Алдсаныг олгон, айхуйд сахиму. Өдөр харуулдан, шөнө манан
- 12а. ивээмү. Эрхлэн хөнгөчлөн тумрах<sup>31</sup> минь бус өөрийн чадал буян мөхөс, эдүгээ энэ цагийн ард зөрүү, хамаг бүхэн хомс, гагцхүү эгээрлийн газар ивээлт хайрхаддаа итгэн гуйж залбирал бөлгөө.  
Тэнгэрийн нүдээр харж  
Тэнгэрийн чихээр сонсч  
Гэгээн толиор тольдож  
Дүрвэхгүй рид хувилгаанаараа илт тэтгэмү. Манай
- 12б. үйлдвэр олон, явдал авир бүдүүн, далдыг мэдэхгүйн эрхээр газар ус, мод чулуу хөндөх, онгон газарт хоноглох, үдлэх, бууц засах тэргүүтэн үйл юуныг үйлдэвч ундууцах, дамарлах<sup>32</sup>, атаацах, тохуурхах, өслөх тэргүүтэн үгүй харин явдал хэрэгт маань дэмжмү Эртээс ивээн өршөөсөн ачийг ачлах
- 13а. ба жич нүүр болгон өргөх зоог бэлэг \билиг\ эдгээрийг хүлээн авч, хуримлан цэнгэж, гуйн залбирагсдыг минь мөн ёсоор болгон зохиому. Хамгийг айлдагч бурхан Шагжамунийн зарлигт хилэнц юуныг ч бүү үйлд. Буяныг хотол төгөлдөрөөр эдлэгтүн. Өөрийн сэтгэлээ

<sup>29</sup> Мал туувар хэмээсэн утга. Судрыг хөрвүүлж хэвлүүлсэн судлаачид “дуулга” хэмээн ташаа уншсан бололтой.

<sup>30</sup> Мөн судлаачид “орилох” хэмээн ташаа уншжээ. “Урилах” буюу уурлах, хилэгнэх гэсэн утга.

<sup>31</sup> “Тунирхах” хэмээсэн утга. /Монгол хэлний толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999. 241 дүгээр талд үз/.

<sup>32</sup> “Дамарлах”- доог, ёж үг. Элэг доог хийх үгийн халгуу дуудлага. /Монгол хэлний толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999. 253 дүгээр тал, Сэцэнцөгт. Монгол үгсийн яздуурын толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1988. 206 дүгээр талд үз/.

- амуутгагтун<sup>33</sup>. Энэ нь бурханы сургаал үзүүлэгдэхүүн бөлгөө. Хорин<sup>34</sup> үйлдсэн
- 136.** юун бүгдийг одон бүргэлзлэл, зул ба заль сүүдэр, усан цөврүү, зүүд, цахилгаан, үүл адил үзэгтүн. Мэснээс үл айх хэн үгүй. Үхэх амийг бүгдээр цээрлэмүй. Өөрийн биенээс үлгэр авч бусаддаа хорлол бүү үйлдэгтүн хэмээсэн номын өглөг болгон өргөсүгэй Сансар нирвааны сайн өлзий, цог заль, хүч учрал, нас буян, сайн алдар, идээ
- 14а.** хувчид, эд малын хамаг хишиг иртүгэй. Хурай хурай. Хэзээд юунаар ч мөхөсдөхгүй их хишгийг өршөөмү. Огторгуйн санг баян дэлхийн эзэд минь ээ, Аяа, гурван эрдэнийн адистид ба бид нутгийн ард дахины буян өлзий, үнэн номын чанар, сайн бэлгүүдийн хүчээр дэлхийн эздэд харшгүй цагаан зүгийг тэтгэх сүр
- 14б.** жавхлан нь бадрах болтугай. Орны эздийн аль таалсан бүгд миний энэ тахилаас гарч тааллыг тань гүйцэлдүүлэх болтугай. Хайрхад нар ба доор хоргодсон бид нар цөм эх хөвгүүн адил амраг сайхнаар оршиж, түүний хүчээр орон дахин даяар амар жаргах маань болтугай. Эдүгээ элхийн эздийг тахихдаа алдал гэм болсон буй аваас манай
- 15а.** мунхаг тэнэгийн явдлыг уучлан хүлцмү. Манай өргөснийг авч өчсөнийг тунгаан тус тус ордондоо тэхрээд<sup>35</sup>, жич залах бүр залран ирсээр насад харгалзан өршөөмү. Орны эздэд минь ээ.
- Эх ачит лам ядам бурхадын өлзий хутаг орштугай.  
Аврал гурван эрдэнийн өлзий хутаг орштугай.  
Эх баатар дагинасын өлзий хутаг
- 15б.** орштугай.  
Хүчит номын сахиусан нарын өлзий хутаг орштугай.  
Тэнгэрс орны эздийн өлзий хутаг орштугай.  
Аль санасан хэрэг бүтэхийн өлзий хутаг орштугай.  
Өдөр шөнийн цаг бүгдэд амгалангаар цэнгэхийн өлзий хутаг орштугай” хэмээн өгүүлэгдэх.  
*Ер дээдсийн зохиосон дэлхийн эздийн тайлганы судар нэн олон*
- 16а.** *адис ихтэй, эртнээс өлзий болсоор ирсэн гэвч цом Төвдийн хэл бөгөөд газрын эздэд заримууд нь үл ухах болзошгүй. Мөн энгийн монголчууд мэдэхгүй. монголчилбоос уг төвдийн өгүүлэх байдлыг дагалдуулж учраар монголын хэлэнд явхийтэл нийлэлцэхгүй бөгөөд уг санаа үнээр сайтар бүрнээр мэдэхүйеэ бэрхлиг шинги<sup>36</sup> санаваас Монголын дэлхийн эздэд Монголын идээ бэлдэж, Монголын үгээр*
- 16б.** *зориулж, учир зоригоо дуудаж өгүүлбээс харин Монгол орондоо өлзий билигтэй (бэлгэтэй) гэхийн гадна энгийн монголчууд учрыг мэдэж сүслэлдэх санаа олму хэмээх санаа шүтэж, бөгд нарын зохиосон судруудын байр санаа авч ийн эвсүүлэв.*  
*Мангаалам. Ум ма ни бад мэ хум.*

Төгсгөлийн эл үгнээс зохиогчийн үзэл бодол, зорилго харагдаж буй агаад эх хэлээрээ уншлагыг уншиж, Монголынхоо газар усны эздийг тайж тахих нь илүү өлзий дэмбэрэлтэйн зэрэгцээ хүмүүс ч утга учрыг ухаарч, улам сүслэх магад хэмээсэн санааг илэрхийлсэн нь өдгөө ч бурханы ном судрыг монгол хэлээр уншдаг болох тухай зарим хүмүүсийн саналыг бодолцоход илүүдэхгүйг харуулж буй гэлтэй.

<sup>33</sup> Алжаал зүдрэлээ тайлж, сэтгэл санаагаа амар тайван болгож, номхтгох гэсэн утга.

<sup>34</sup> “Хуран” хэмээх үг бололтой.

<sup>35</sup> “Тэхрэх” - эгэх замдаа орох, буцах гэсэн утгатай. /Монгол хэлний толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999. 2300дугаар тал/. Судлаачид “дэлгэрээд” гэж уншсан буй.

<sup>36</sup> “Шигийг” хэмээсэн үг бөгөөд ихэвчлэн буриад аялгуунд ийн хэлдэг ажээ.

**Ашигласан ном**

Буддын шашин, соёлын тайлбар толь. 2 боть. УБ. 1999.

Бямбаа, Р. Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл.

Монголчуудын төвд хэлт бүтээлийг судлах монгол билиг цуврал. УБ. 2004.

Монгол хэлний толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1999.

Сүхбаатар, О. Монголын тахилгат уул усны сангийн судар оривой". УБ. 2000.

Сүхбат, П. Богд Очирваань Отгонтэнгэр хайрханы түүх шастир, тайлга тахилга, зан үйлийн товчоон оривой. УБ. 2004.

Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1988.

Уул овооны сан тахилгын суорууд. Ерөнхий редактор Д. Мөнхсайхан. УБ. 2004.

Хорин наймт тайлбар толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1994.

*Хавсралт*

